



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### Компанийн 2022 оны үйл ажиллагааны нийт зардлын төсөв, төлөвлөгөөнд тодотгол хийх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2 ба 3.2 дахь заалтууд, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 336 дугаар тогтоол, Сангийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 99 дугаар тушаал, 2022 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 181 дугаар тушаал болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтууд, Аудитын хорооны дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн нэмэлт хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдахтай холбоотой мэргэжлийн байгууллагын болон зөвлөх үйлчилгээний нийт зардлын төсөвт өртгийн дээд хязгаарыг 981,455,000 төгрөгөөр тогтоож, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд компанийн тайлант хугацааны үйл ажиллагааны зардлыг 236,310,039 төгрөгөөр бууруулж, компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон санхүүгийн төсөв, төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааны нийт зардлын төсвийг энэхүү тогтоолын хавсралт 1-д заасны дагуу тодотгосугай.
2. Компанийн нэмэлт хувьцааг гаргахтай холбоотой мэргэжлийн байгууллагын болон зөвлөх үйлчилгээний зардлыг зах зээлийн дундаж үнэд нийцүүлэн, боломжит хэмжээгээр хэмнэж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны нийт зардлын төсөвт тодотгосон, биржийн арилжааны шимтгэлийн үнийн дүнгээс тооцдог "Зохицуулах үйлчилгээний хөлс"-ийг бууруулах талаар Санхүүгийн зохицуулах хороонд санал, хүсэлт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

1522010047

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.СҮХ-ОЧИР



**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК-ИЙН  
2022 ОНЫ ОРЛОГО, ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ**

#	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны				
			төлөвлөгөө	гүйцэтгэл 2022/09/25	ХБГ 2022/12/31	Тодотгол +/- 2022/12/31	Тодотгосон дүн*
<b>A</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>5,520,926</b>	<b>6,033,833</b>	<b>2,024,259</b>	<b>5,123,959</b>	<b>-</b>	<b>6,033,833</b>
1	Хувьцааны арилжааны шимтгэл	2,189,894	2,369,874	912,750	2,369,874		2,369,874
2	Бондын арилжааны шимтгэл	955,513	1,024,151	211,468	301,228		1,024,151
3	ХОС-ын нэгж эрх арилжааны шимтгэл	402,700	201,350	19,176	29,692		201,350
4	Гишүүнчлэлийн жилийн хураамж	70,569	72,470	51,898	72,470		72,470
5	Терминал ашигласны хураамж	58,145	61,691	45,382	61,691		61,691
6	Бүртгэх үйлчилгээний орлого	799,533	1,596,990	220,387	1,638,707		1,596,990
7	Бүртгэлтэй компанийн жилийн хураамж	253,224	317,932	350,264	371,264		317,932
8	Сургалтын орлого	13,000	54,000	-	-		54,000
9	Мэдээллийн үйлчилгээний орлого	136,627	219,279	134,405	200,505		219,279
10	Хүүгийн орлого	19,302	20,000	-	-		20,000
11	Бусад орлого	112,443	96,098	73,075	73,075		96,098
12	МИТ ашиглалтын орлого	509,974	-	5,455	5,455		-
<b>B</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>2,168,807</b>	<b>3,269,595</b>	<b>1,327,834</b>	<b>4,239,600</b>	<b>1,084,790</b>	<b>4,354,385</b>
1	Ажилтнуудын цалин хөлс	692,281	1,149,350	738,296	1,105,643	(43,707)	1,105,643
2	НДШ-ийн зардал	92,047	155,162	93,638	149,699	(5,463)	149,699
3	Удирдлагын зардал	37,725	117,498	59,241	117,498		117,498
4	Материал, бичиг хэрэг	11,871	17,766	13,170	17,132	(635)	17,132
5	Харилцаа холбооны зардал	6,061	7,827	4,125	7,407	(420)	7,407
6	Интернет ашиглалт	16,922	19,747	13,491	19,747		19,747
7	Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	9,411	11,084	5,842	8,481	(2,603)	8,481
8	Урсгал засвар	15,511	50,012	14,641	50,012		50,012
9	Цахилгаан, дулаан, ус, хог	45,320	55,560	25,286	52,796		55,560
10	Албан томилолт	-	62,390	-	-	(62,390)	-
11	Сургалт семинар	2,931	25,615	4,786	9,786	(1,000)	24,615
12	Нийгэм соёлын арга хэмжээ	23,417	26,836	13,405	26,836		26,836
13	Маркетинг, бизнес харилцааны зардал	2,991	220,000	34,366	100,100	(119,900)	100,100
14	Мэдээлэл технологийн зардал	10,246	90,082	16,819	90,082		90,082
15	Бусад зардал	23,872	27,358	5,020	27,166	(192)	27,166
16	Элэгдлийн зардал	239,905	497,192	157,489	400,000		497,192
17	Зохицуулах үйлчилгээний хөлс /СЗХ/ *	-	-	85,858	231,570	231,570	231,570
18	МИТ ашиглалтын зардал:	938,295	736,116	42,362	844,191	108,075	844,191
	Үүнд: МИТ - Элэгдлийн зардал	144,377	-	-	-		
	МИТ - Төслийн зардал	793,918	736,116	42,362	844,191	108,075	844,191
19	IPO хийхтэй холбоотой мэргэжлийн байгууллагын болон зөвлөх үйлчилгээний зардал *	-	-	-	981,455	981,455	981,455
<b>B</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ</b>	<b>3,352,119</b>	<b>2,764,239</b>	<b>696,425</b>	<b>884,359</b>	<b>(1,084,790)</b>	<b>1,679,449</b>
Г	Гадаад валютын ханшийн бодит бус цэвэр орлого	58	-	60,062	60,062	-	-
<b>D</b>	<b>ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР АШИГ (B+Г)</b>	<b>3,352,177</b>	<b>2,764,239</b>	<b>756,487</b>	<b>944,421</b>	<b>(1,084,790)</b>	<b>1,679,449</b>